



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар A/150

Улаанбаатар хот


Элсэлтийн журам батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Гадаадын болон дотоодын дээд боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусlamж олгох, дэмжлэг үзүүлэх журам" 102 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрөөс дэмжлэг үзүүлэх журам" 103 дугаар тогтоол, Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2024 оны "Оюутан элсүүлэх журам" А/143 дугаар тушаал, БШУ-ы сайдын 2024 оны "Босго оноо тогтоох тухай" А/170 дугаар тушаал, "МУБИС-ийн дүрэм"-ийн 4.4.1, "Сургалтын журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2024-2025 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх элсэлтийн журмыг 1 дүгээр хавсралтаар, оюутан элсүүлэх хөтөлбөр, мэргэжлийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургуулийн элсэлтийн журам, багц хөтөлбөрүүдийг элсэгчдэд танилцуулах, элсэлтийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулахыг бүрэлдэхүүний сургуулийн захирал, сургалт, цахим шилжилтийн хэлтэс, бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба болон элсэлтийн төв, дэд комисст тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсан холбогдуулан оюутан элсүүлэх үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Сургалт, хамтын ажиллагааны газрын дарга (Д.Соронзон)-д үүрэг болгосугай.



20241090

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬД 2024-2025 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Монгол Улсын Боловсролын Их Сургууль (цаашид МУБИС гэнэ)-ийн бакалавр, магистрантур, докторантурын хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Гадаадын болон дотоодын дээд боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусlamж олгох, дэмжлэг үзүүлэх журам" 102 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрөөс дэмжлэг үзүүлэх журам" 103 дугаар тогтоол, Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, БШУ-ны сайдын 2024 оны "Оюутан элсүүлэх журам" A/143 дугаар тушаал, БШУ-ны сайдын 2024 оны "Босго оноо тогтоох тухай" A/170 дугаар тушаал, МУБИС-ийн Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, МУБИС-ийн Сургалтын журам, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон энэхүү журам (цаашид элсэлтийн журам гэнэ)-ыг баримтална.
- 1.2 МУБИС-д элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", зохих шаардлага хангасан бүртгүүлэгчдэд олгох бичиг баримтыг "суралцах эрхийн бичиг", элсүүлэх оюутны тоог "хяналтын тоо", хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулж, суралцах эрхийн бичиг олгогдсон бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн систем (<https://https://elselt.msue.edu.mn/>)-ийг "элсэлтийн нэгдсэн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн төв комисс", "элсэлтийн дэд комисс" гэнэ.
- 1.3 МУБИС-д Улаанбаатар хот болон орон нутаг, гадаад улсаас элсүүлэх элсэгчийн хяналтын тоог МУБИС-ийн Удирдах Зөвлөл БШУ-ны Яамнаас тогтоосон аргачлалын дагуу тогтооно.
- 1.4 МУБИС-ийн захиргааны зөвлөлөөр баталсан элсэлтийн журам, тусгай зөвшөөрөл бүхий сургалтын хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалт (цаашид ЭЕШ гэнэ)-ын оноо, голч дүн, элсэгчдэд тавигдах шаардлага, тэтгэлэг, тэтгэмж, бусад холбогдох мэдээллийг МУБИС-ийн цахим хуудас (<https://web.msue.edu.mn/>) болон элсэлтийн нэгдсэн системд байршуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН ТӨВ, ДЭД КОМИССЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Элсэлтийн төв комиссыг МУБИС-ийн захирлын тушаалаар, дэд комиссыг бүрэлдэхүүний сургуулийн захирлын тушаалаар тус тус баталгаажуулж, байгуулна.
- 2.2 МУБИС-ийн элсэлтийн төв комисс нь Сургалт, хамтын ажиллагааны газрын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь бүрэлдэхүүний сургууль, албадуудын холбогдох албан тушаалтнууд байна.
- 2.3 МУБИС-ийн элсэлтийн дэд комисс нь Бүрэлдэхүүний сургуулийн захирал, нарийн бичгийн дарга нь Хөтөлбөрийн албаны дарга, гишүүдэд нэгжийн холбогдох албан тушаалтнууд байна.

Элсэлтийн төв комиссын үйл ажиллагаа

- 2.4 Элсэлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.
- 2.5 Элсэлтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн, оногдсон төсвийг зарцуулна.
- 2.6 Оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргаан, тухайн журмаар зохицуулагдах боломжгүй асуудлыг тухайн нэгжийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.
- 2.7 Элсэлтийн холбоотой цаг үеийн мэдээ, мэдээлэл, удирдлагын шийдвэрийг дэд комисс, нэгжүүдэд тухай бурд хүргэж, ажиллана.
- 2.8 Элсэлтийн сурталчилгаа, маркетингийн ажилд хяналт тавина.

2.9 Элсэлтийн дэд комиссын гишүүдээс бүрдсэн элсэлтийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Дэд комиссын үйл ажиллагаа

2.10 Элсэлтийн төв комиссын шийдвэрийн дагуу бүрэлдэхүүний сургуульд хуваарилсан дүүрэг, орон нутагт элсэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

2.11 "МУБИС-ийн сурталчилгааны баг"-тай элсэлтийн сурталчилгаа, маркетингийн чиглэлээр хамтарч ажиллана.

2.12 Элсэлтийн хяналтын тооны гүйцэтгэлийг хангахаар элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

2.13 Элсэлтийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг элсэлтийн төв комисст тайлагнана.

2.14 МУБИС-ийн элсэлтийн сурталчилгааг орон нутаг, Улаанбаатар хотын дүүргүүдэд зохион байгуулах, элсэлтийн танилцуулга, хурал, уулзалт зохион байгуулна.

2.15 Шаардлага хангасан элсэгчдээ, элсэлтийн төв болон дэд комиссоос олгосон квотын дагуу МУБИС-ийн урилга, суралцах эрхийн бичгийг олгоно.

2.16 Оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргаан, тухайн журмаар зохицуулагдах боломжгүй асуудлыг элсэлтийн төв болон дэд комисст уламжлан шийдвэрлүүлнэ.

2.17 Үйл ажиллагааны тайланг элсэлтийн төв болон дэд комисст цахим шуудангаар илгээж, тайлагнана.

Элсэлтийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүрэг

2.18 БШУЯ-ны "Оюутан элсүүлэх журам"-ын 3.1-3.4, 4.1-4.5-т дахь заалтыг дагаж мөрдөнө.

ГУРАВ. БАКАЛАВРЫН ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Боловсролын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагын (БҮТ) зохион байгуулсан ерөнхий шалгалтын оноог үндэслэн оюутан элсүүлнэ.

3.2 Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн мэргэжлийн (хавсралт-1)-д заасан хичээлээр 2 жил 6 сарын хүчинтэй хугацаатай элсэлтийн ерөнхий шалгалтын QR код бүхий цахим батламж, Монгол хэл бичгийн шалгалтын босго оноог хангасан QR код бүхий цахим батламж, БШУЯ-аас тогтоосон босго оноог хангасан, бүрэн дунд боловсролын гэрчилгээтэй байна.

3.3 Бүртгүүлэгч нь өөрийн хүсэлтээр элсэх хөтөлберийг сонгох ба хэдэн ч хөтөлбөрт хүсэлт гаргаж болно.

3.4 Боловсролын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагын зохион байгуулсан ерөнхий шалгалтын оноог үндэслэн оюутан элсүүлнэ. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн мэргэжлийн хавсралтад заасан хичээлээр 2022-2024 онд элсэлтийн ерөнхий шалгалт өгч, БШУЯ-аас тогтоосон босго оноог хангасан байна.

3.5 Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж хуудас нь шалгалт өгсөн өдрөөс хойш 2 жил 6 сарын хугацаанд хүчинтэй байна.

3.6 Элсэгч зарим мэргэжил /хөтөлбөр/-ээр "Ур чадварын шалгалт" өгнө.

3.7 "Ур чадварын шалгалт"-ыг элсэн суралцах мэргэжлийн онцлогтой уялдуулан бичгийн ажил, тест, ярилцлага, кейс дээр ажиллуулах, натюроморт зурах, сэдэвт зохиомж зурах, дуулах, бүжиглэх, хөгжимдэх, жүжиглэх, эсээ бичих, видео танилцуулга, сонсгол, хэмнэл шалгах, бие бялдрын бэлтгэгдсэн байдал, багшлах авьяас сонирхлын тест, эсээ зэрэг хэлбэрээр авч, шалгуулагчийн ур чадварыг үнэлнэ.

3.8 Элсэгчийн ур чадварын шалгалтын оноо нь тухайн шалгалтыг өгсөн сургууль, мэргэжлийн хувьд л хүчинтэй байна.

3.9 Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувь буюу анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-аас 800-ийн хооронд байна)-г хөтөлбөр бүрээр энэхүү журамд заасан аргачлалаар тооцно. Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

Анхны оноо (A)

10-59

60-64.9

65-69.9

70-74.9

Хэмжээс оноо (X)

200-479

480-519

520-559

560-599

9087702 дк 0021051159

75-79.9	560-639
80-84.9	640-679
85-89.9	680-719
90-94.9	720-759
95-100	760-800



- 3.10 Ур чадварын шалгалтад 60 (хэмжээст оноогоор 480) болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.
- 3.11 Шалгуулагчийн ур чадварын шалгалтын оноо тухайн шалгалтыг өгсөн сургууль, хөтөлбөрийн хувьд хүчинтэй байна.
- 3.12 Элсэлтийн ерөнхий шалгалтын зорилго нь сургуулийн бакалаврын хөтөлбөрт-элсэн суралцаад шаардагдах ерөнхий мэдлэг, ур чадварын түвшин тогтоож, эрэмбэлэхэд оршино.
- 3.13 Элсэлтийн ерөнхий шалгалт нь монгол хэл, математик, нийгэм судлал, Монгол Улсын түүх, англи хэл, орос хэл, хими, физик, биологи, газарзүйн судлагдахууны I (заавал судлах) ба II (гүнзгийрүүлж сонгон судлах) хөтөлбөрийн агуулгад үндэслэн боловсруулсан 2 түвшинт тестийн хэлбэртэй байж болно. Элсэлтийн ерөнхий шалгалт өгч буй бүх иргэн Монгол хэл, бичгийн шалгалтыг заавал өгнө.
- 3.14 Элсэлтийн үйл ажиллагааг жилд 2 удаа зохион байгуулна.

Элсэлтийн хяналтын тоо тогтоох

- 3.15 Өвлийн буюу 2 дахь удаагийн элсэлтийг Удирдах зөвлөлөөс намар баталсан элсэлтийн хяналтын тоог гүйцэх байдлаар зохион байгуулна. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжил /хөтөлбөр/-ээр нэмэлт элсэлт авах хяналтын тоог хаврын элсэлтийн тоотой нэгтгэсэн байдлаар БШУЯ-ны баталсан аргачлалын дагуу батлуулж, элсэлт авч болно.
- 3.16 Дээд боловсролын сургалтын байгууллага бакалаврын сургалтын хөтөлбөрт оюутан элсүүлэх хяналтын тоог тухайлсан хөтөлбөр бүрээр тодорхойлно. Элсэлтийн хяналтын тоог дараах алхмаар тодорхойлно. Үүнд:
- Багшийн ачаалал: Багшийн ачаалал, тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх сургалтын үйл ажиллагааны ачааллыг тооцоолж, элсэлтийн боломжит бүлгийн тоог хөтөлбөр бүрээр тодорхойлох;
 - Орчин нэхцэл: Хөтөлбөр бүрээр тодорхойлсон нийт бүлэгт сургалтын анги танхим болон лаборатори хүрэлцээтэй эсэхийг тооцох;
 - Хичээллэх боломжтой бүлгийн тоонд үндэслэн элсэлтийн хяналтын тоог тодорхойлно.

2. БАКАЛАВРЫН ХӨРВӨХ, ЭЧНЭЭ, ЗЭРЭГ АХИУЛАХ ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.2.1 Хөрвөх хөтөлбөрт бүртгүүлэгч нь бакалаврын зэрэгтэй байна.
- 2.2.2 Хөрвөх хөтөлбөрт бүртгүүлэгчийн өмнөх бакалаврын дипломын мэдээлэл БШУЯ-ны Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд баталгаажсан байна.
- 2.2.3 МУБИС-ийг дээд боловсролын дипломын зэрэгтэйгээр төгссөн төгсөгчийг зэрэг ахиулан сургана.

3.3 ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, СУРАЛЦАХ ЭРХИЙН БИЧИГ ОЛГОХ

- 3.3.1 Улаанбаатар хотоос элсэгч нь дараах хэлбэрээр элсэх хүсэлт гаргаж, суралцах эрхийн бичгээ авна. Үүнд:
- Элсэлтийн нэгдсэн систем (<http://elselt.msue.edu.mn/>)-д Боловсролын үнэлгээний төвийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан бүртгүүлнэ. Шаардлага хангасан элсэгчдэд суралцах эрхийн бичгийг цахим шуудангаар илгээнэ.
 - МУБИС-ийн элсэлтийн төв комисст ирж бүртгүүлэн суралцах эрхийн бичиг авна.
- 3.3.2 Орон нутгаас элсэгч нь дараах хэлбэрээр элсэх хүсэлт гаргаж, суралцах эрхийн бичгээ авна. Үүнд:
- Элсэлтийн нэгдсэн систем (<http://elselt.msue.edu.mn/>)-д Боловсролын үнэлгээний төвийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан бүртгүүлнэ. Шаардлага хангасан элсэгчдэд суралцах эрхийн бичгийг цахим шуудангаар илгээнэ.

- МУБИС-ийн орон нутагт ажилласан багшаар дамжуулан суралцах эрхийн бичиг авна.
- Урилгаар элсэгч нь элсэлтийн төв комисст урилгаа бүртгүүлэн суралцах эрхийн бичиг авна.
- МУБИС-ийн элсэлтийн төв комисст ирж бүртгүүлэн суралцах эрхийн бичиг авна.

3.3.3 Урилгаар элсэх: МУБИС-д элсэх урилгыг дараах шаардлага хангасан сурагчдад олгох бөгөөд элсэлтийн ерөнхий шалгалт өгч, босго оноог хангасан байна. Үүнд:

- Сэтгүүлч мэргэжлээр элсэгчдийг хэвлүүлсэн зохиол, бүтээл, нийтлэл зэрэг уран бүтээлийн чанар, мөн аймаг, улсын хэмжээний "Хүрэл тулга" болон түүнтэй дүйцэх уралдаанд амжилттай оролцсоныг гэрчлэх баримт, өргөмжлөл, үнэмлэх зэргийг үндэслэн сонгон шалгаруулж, хяналтын тоонд багтаан урилга олгоно.
- Олон улс, улсын чанартай олимпиадад оролцож байр эзэлсэн сурагчдад тухайн мэргэжлийн чиглэлээр суралцах урилгыг хяналтын тоонд багтаан урилга олгоно.
- Дүрслэх урлаг, Техник-технологи, дизайн, зураг зүй чиглэлээр улс, аймаг, нийслэлийн олимпиад, уралдаан, үзэсгэлэн /техник технологийн болон робот, техник спорт, дизайн зохион бүтээлт, зураг зүйн олимпиадууд, уран зураг, хувцас загварын улсын уралдаан, сурагчдын бие даасан үзэсгэлэн/-д I-III, мөн тусгай байр эзэлсэн сурагчийг тухайн мэргэжлийн чиглэлээр элсэлтийн хяналтын тоонд багтаан урилга олгоно.
- Спортын төрлөөр мастер цолтой, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон, олон улсын тэмцээнд шагналт байр эзэлсэн, улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний гурван байрт шалгарсан сурагчийг биеийн тамир, спортын суралцах сонирхлыг үндэслэн элсэлтийн хяналтын тоонд багтаан тухайн мэргэжлийн чиглэлээр урилга олгоно.
- Сум, аймаг, орон нутаг, сургууль нь өөрийн хэрэгцээнд үндэслэн шаардлагатай мэргэжлийн багшийг бэлтгэх хүсэлтээ илэрхийлж, гэрээгээр тодорхой үүрэг, хариуцлага хүлээх бол шаардлага хангасан элсэгчдийг элсэлтийн хяналтын тоонд багтаан урилга олгоно.
- Гадаад улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг Кембрижийн AS /advanced subsidiary/, A /advanced/, болон IB /international baccalaureate/, TOEFL IBT 50, SAT 1500, TOEIC 600, IELTS 7, Хятад хэлний HSK 4.0, Герман хэлний CEFR B2, C1, Солонгос хэлний TOPIK 3, KLPT 3, Орос хэлний TRKI A1, Япон хэлний N3-аас дээш оноотой сурагчдад тухайн мэргэжлийн чиглэлээр элсэлтийн хяналтын тоонд багтаан урилга олгоно.
- Багш болох чин хүсэл эрмэлзэл, авьяас сонирхолтой, өөрөө хөгжлийн бэрхшээлтэй, үе залгамжилж боловсролын салбарт ажилласан болон амьжиригааны баталгаажих түвшнеөс доогуур орлоготой өрхийн сурагчийг элсэлтийн шаардлага хангасан тохиолдолд хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

3.3.4 Нэмэлт элсэлт: Нэмэлт элсэлтийг жич зарлах бөгөөд бүртгүүлэгч нь дараах хэлбэрээр бүртгүүлж, суралцах эрхийн бичиг авна. Үүнд:

- Элсэлтийн нэгдсэн систем (<http://elselt.msue.edu.mn/>)-д BYT-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан бүртгүүлнэ. Шаардлага хангасан элсэгчдэд суралцах эрхийн бичгийг цахим шуудангаар илгээнэ.
- МУБИС-ийн элсэлтийн төв комисст ирж бүртгүүлэн суралцах эрхийн бичиг авна.

3.3.5 Хөрвөх ангид элсэлтийг хичээлийн жилийн намар болон хаврын улирал эхлэхээс 14 хоногийн өмнө бүртгэнэ.

3.3.6 Хөрвөх хөтөлбөрийн элсэгчдийн хичээлийн кредитийн дүйцүүлэлтийг тусгай журмаар зохицуулна.

3.3.7 Элсэлтийн материалыг хуурамчаар үйлдвэл үүсэх хариуцлагыг шалгуулагч өөрөө хүлээнэ.

4. ЭЛСЭГЧДИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

3.4.1 Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг эх хувиар бүрдүүлж, өөрийн биеэр болон онлайнаар бүртгүүлнэ. Үүнд:

- Бүрэн дунд боловсрол буюу түүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичгийн хуулбар (E-Mongolia, TYЦ машины лавлагаа)
- Боловсролын үнэлгээний төвийн системээс хэвлэсэн QR код бүхий ерөнхий шалгалтын онооны батламжийн хуудас (E-Mongolia, TYЦ машины лавлагаа)

- Монгол хэл бичгийн шалгалтын босго оноог хангасан QR код бүхий цахим батламжийн хуудас (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
- МУБИС-д суралцах эрхийн бичиг
- Иргэний үнэмлэхийн хуулбар (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
- 3x4 хэмжээтэй цээж зураг-2%

3.4.2 Суралцах эрхийн бичиг авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчийг элсэн суралцахаас татгалзсан гэж үзэн элсэх эрхийг хүчингүйд тооцно.

3.4.3. Бакалаврын хөрвөх хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг бурдуулж, ~~өөрийн биеэр~~ бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанад ирж бүртгүүлнэ. Үүнд:

- Өмнөх бакалаврын дипломын хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
- 3x4 хэмжээтэй цээж зураг-2%
- Ажлын газрын тодорхойлолт (Багш мэргэжлээрээ ажилладаг бол)
- Өргөдөл

3.4.4. Бакалаврын зэрэг ахиулах хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг бурдуулж, өөрийн биеэр бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанад ирж бүртгүүлнэ. Үүнд:

- Өмнөх дипломын хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
- 3x4 хэмжээтэй цээж зураг-2%
- Өргөдөл

3.4.5. Бакалаврын эчнээс хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг бурдуулж, өөрийн биеэр бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанад ирж бүртгүүлнэ. Үүнд:

- Боловсролын үнэлгээний төвийн системээс хэвлэсэн QR код бүхий ерөнхий шалгалтын онооны батламжийн хуудас (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- 3x4 хэмжээтэй цээж зураг-2%
- Өргөдөл
- Спортын өндөр зэрэглэлийн тамирчны үнэмлэхийн хуулбар

5. БАКАЛАВРЫН ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ, ТЭТГЭМЖ

Засгийн газрын тэтгэлэг:

Тэтгэлгийн хамрах хүрээ:

- Багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч
- Багш мэргэжлээр бакалаврын хөтөлбөрт суралцагч
- Дадлагжигч багш
- Боловсролын /01/ чиглэлээр магистрын хөтөлбөрт суралцагч
- Багш мэргэжлээр хөрвөх бакалаврын хөтөлбөрийн суралцагч
- 15 жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхэд

3.5.1 Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 103 тоот тогтоол, Боловсролын зээлийн сантай байгуулсан гэрээний дагуу Багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр /хөрвөх/ 2.7 голчтой, хөдөө орон нутагт 3-аас доошгүй, эсхүл нийслэлд 5-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан тохиолдолд суралцагч сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэгтэй.

3.5.2 Боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индексийн ерөнхий чиглэл (01)-ээр суралцахаар сонгосон байх, өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 3.0-оос доошгүй байх, төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад хөдөө орон нутагт 3-аас доошгүй, эсхүл нийслэлд 5-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан тохиолдолд суралцагч сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэгтэй.

3.5.3 Суралцагчийн эцэг, эхийн аль нэг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй багш, ажилтнаар ажилласан байх, төрийн өмчийн сургалтын байгууллагад тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлээр дэд бакалавр, бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрийг сонгосон 2.7 голчтой суралцагч сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэгтэй.

3.5.4 Хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч 3 болон 4 дүгээр дамжааны суралцагч байх, суралсан хугацааны голч дүн 2.7 болон түүнээс дээш байх, оюутнуудад сар бүр хөдөлмөрийн хөлслний доод хэмжээгээр тооцож гурван сар тутамд 1 удаа олгох сургалтын төлбөрийн тэтгэлэгтэй.

3.5.5 МУЗГ-ЫН 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/103 дугаар тогтоолын дагуу "Багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төреөс дэмжлэг үзүүлэх журам"-ын 4.1, 5.1 дэх заалтын дагуу материалыг бүрдүүлэн тэтгэлэгт хамруулна.

Нийтлэг шалгуур:

- Монгол улсын иргэн байх
- Элсэлтийн журмын дагуу элссэн, боловсролын цахим мэдээллийн системд бүртгэгдсэн байх
- Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр суралцахаар сонгосон байх

Тэтгэлэг баталгаажих процесс:

- Суралцагч суралцаж төгсөөд төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад орон нутагт 3-аас доошгүй жил, нийслэлд 5-аас доошгүй жил тогтвортой ажиллах заасан шаардлагыг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулснаар тэтгэлэг баталгаажна.

МУБИС-ийн тэтгэлэг, тэтгэмж:

3.5.5 Багш бус мэргэжлийн ЭЕШ-ын 500-аас дээш оноотой эрэгтэй элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 70%-ийн тэтгэлэг олгоно.

3.5.6 Багш бус мэргэжлийн ЭЕШ-ын 500-аас дээш оноотой дараах хөтөлбөрөөр элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлэг олгоно. Үүнд:

1. Программ хангамж
2. Экологи
3. Аялал жуулчлал /туүх, аялал жуулчлал/
4. Хэл, уран зохиол
5. Спортын дасгалжуулагч
6. Аялал жуулчлал /спорт/
7. Хувцасны дизайн
8. Боловсрол судлал
9. Нийгмийн ажил
10. График дизайн
11. Сэтгүүл зүй
12. Архив судлал
13. Нийгмийн ажил, хүүхдийн арга зүйч

3.5.8 Спорт тоглоомын (волейбол) төрлөөр олон улсын тэмцээнд шагналт байранд шалгарсан, улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний гурван байр эзэлсэн 5 хүртэлх элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 100%-ийн тэтгэлэг олгоно. Тэтгэлэгт хамрагдах элсэгчдийг Биеийн тамирын сургуулийн саналыг МУБИС-ийн Захиргааны зөвлөлөөр баталгаажуулна.

3.5.9 Засгийн газрын болон МУБИС-ийн тэтгэлэг, тэтгэмжийг элсэгчдэд давхцуулан олгохгүй болно.

ДӨРӨВ. АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТЫН ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. ЭЛСЭЛТ, БҮРТГЭЛ

4.1.1. Ахисан түвшний хөтөлбөрийн алба нь ахисан түвшний сургалтын бүртгэл, элсэлтийг зохион байгуулж, суралцах эрхийн бичиг олгоно.

4.1.2. Элсэлтийг хичээлийн жилд гурван удаа зохион байгуулна. Элсэлтийн зарыг сургалт эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө сургуулийн веб сайтад байршуулж, бүртгэлийн системийг нээнэ.

4.1.3. МУБИС-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хөтөлбөрөөр магистрант, докторантыг элсүүлнэ.

4.1.4. Бакалаврын дипломын голч дүн 2.7-оос дээш тохиолдолд магистрын хөтөлбөрт, магистрын дипломын голч дүн 3.3-аас дээш тохиолдолд докторын хөтөлбөрт шууд элсүүлнэ. Голч дүн хүрэхгүй тохиолдолд мэргэжлийн шалгалт авах бөгөөд шалгалтад 70%-иас дээш оноотой тохиолдолд элсүүлэн суралцуулна. Мэргэжлийн шалгалтыг мэргэжлийн тэнхим зохион байгуулна.

4.1.5. Элсэгч нь элсэлтийн нэгдсэн систем дэх хөтөлбөрийн жагсаалтаас суралцах хөтөлбөрөө сонгоно.

4.1.6. Элсэлтийн бүртгэл нь элсэлтийн нэгдсэн систем (<http://elselt.msue.edu.mn/>)-ээр хаягаар хийгдэнэ.

4.2. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

4.2.1. Элсэлтийн өмнөх шатны боловсролын мэдээлэл нь БШУЯ-ны дээд боловсролын удирдлага мэдээллийн системд баталгаажсан байна.

4.2.2. Магистрантурт бүртгүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Бүртгүүлэгч мэргэжлийн чиглэлээрээ бакалаврын зэргийн дипломтой байна.
- Өмнө эзэмшсэн бакалаврын мэргэжлээс өөр чиглэлээр магистрантурын хөтөлбөрт суралцах тохиолдолд сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах бакалаврын зөрүү хичээлийг нөхөн үзнэ. Нөхөж үзсэн хичээлийг магистрын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.
- Бүртгүүлэгч бүртгэлийн системийн анкетыг үнэн зөв бөглөж, дараах бичиг баримтуудыг сканердаж, цахим хэлбэрээр хавсаргана.
 - Цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан/
 - Бакалаврын диплом, хавсралтын хамт

4.2.3 Докторантурт бүртгүүлэгчдэд тавих шаардлага:

- Бүртгүүлэгч нь нь тухайн элсэх мэргэжлийн чиглэлээрээ магистрын зэрэг хамгаалсан байна.
- Өмнө суралцсан магистрын хөтөлбөрөөс өөр чиглэлээр докторантурын хөтөлбөрт суралцах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах магистрын зөрүү хичээлийг нөхөн үзнэ. Нөхөж үзсэн хичээлийг докторын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.
- Бүртгүүлэхдээ бүртгэлийн системийн анкетыг үнэн зөв бөглөж, дараах бичиг баримтуудыг сканердаж, цахим хэлбэрээр хавсаргана.
 - Цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан/
 - Бакалавр болон магистрын диплом, хавсралтын хамт

4.2.4. Бүртгэл дууссаны дараагийн 7 хоногт суралцах эрхийн бичиг олгож бүртгүүлсэн цахим хаягаар сургалтын тухай мэдээллийг хүргэнэ.

4.3. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ

4.3.1 Монгол улсын Засгийн газрын 103 дугаар тогтоолын дагуу 100 хувийн тэтгэлэгт хамрагдах элсэг дараах шаардлагыг хангасан байна.

- Боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцахаар сонгосон байх,
- Бакалаврын дипломын голч дүн 3.0-оос доошгүй байх,
- Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад хөдөө орон нутагт 3-аас доошгүй, эсхүл нийслэлд 5-аас доошгүй жил ажилласан байх,
- Орон нутагт мэргэжлээрээ ажиллаж байгаа багш боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр хөрвөн суралцахаар сонгосон байх, аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн сул орон тоо (үндсэн орон тоо байх)-нд 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан байх

4.3.2. МУБИС-ийн бакалавр, магистрын дипломын голч оноо 3.7-гоос дээш төгсөгчдөд магистр, докторын хөтөлбөрт сургалтын төлбөрийн 20%-ийн тэтгэлэг олгоно.

4.3.3. Хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагын багш, ажилтанд сургалтын төлбөрийн 15%-20%-ийн тэтгэлэг олгоно.

4.3.4. Шаардлага хангасан суралцагч Боловсролын зээлийн сангийн тэтгэлэгт хамрагдаж болно.

ТАВ. ГАДААД ОЮУТНЫ ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 ЭЛСЭЛТ, БҮРТГЭЛ



5.1.1 Боловсролын зэрэг олгох сургалтад хамрагдах суралцах хүсэлтэй гадаадын иргэн нь МУБИС-ийн элсэлтийн нэгдсэн систем (<https://burtgel.msu.edu.mn/>)-д хаягаар цахим хэлбэрээр хүсэлт гаргаж бүртгүүлнэ. Элсэлтийн үйл ажиллагааг бакалаврын зэрэг олгох сургалтын хувьд жилд нэг удаа буюу 8 сард, ахисан түвшний сургалтын хувьд жилд гурван удаа 9, 11, 1 саруудад зохион байгуулна.

5.1.2 БШУЯ-ны "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын "Оюутан элсүүлэх журам"-ын 3.3-т заасны дагуу гадаад иргэдийг элсүүлэн суралцуулна.

5.1.3 Бичиг баримт дутуу, өөр агуулгатай бичиг баримт бүрдүүлэх, холбоо барих хаяг тодорхойгүй байх тохиолдолд элсүүлэх боломжгүй.

5.2 БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

А. БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЭХ ГАДААД ИРГЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.2.1 Бүртгүүлэгч нь Монгол улсын харьялалгүй иргэн байх бөгөөд хууль эрх зүйн хувьд өөрийгөө бүрэн хариуцах чадамжтай байна.

5.2.2 Бүртгүүлэгч нь Монгол хэлний зохих түвшний шаардлага хангасан, монгол хэл, бичгийн шалгалтын 71 онооноос дээш байна. 70-аас доош оноо авсан тохиолдолд Монгол хэл, бичгийн бэлтгэл ангид хэлний түвшнээс шатгаалан 6-18 сар хэлний бэлтгэлд суралцана.

5.2.3 Бүртгүүлэгч нь бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон Монгол улсад мөрдөж байгаа Элсэлтийн ерөнхий шалгалттай дүйцэхүйц тухайн улсын элсэлтийн шалгалтын оноотой байна. Тус шалгалтын оноог Боловсролын үнэлгээний төвөөр элсэлтийн ерөнхий шалгалт руу дүйцүүлэлт хийлгүүлнэ.

5.2.4 Бүртгүүлэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Гадаад паспортын хуулбар /Паспортын нүүрэн хэсгийг дэлгэмэл байдлаар сканердсан хуулбар, хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байх/
- Эрүүл мэндийн хуудас
- Иргэний үнэмлэх /биеийн байцаалт/-ийн хуулбар
- Иргэний үнэмлэхийн монгол хэл дээр баталгаат орчуулга
- Элсэлтийн ерөнхий шалгалттай дүйцэх шалгалтын дүн
- Элсэлтийн ерөнхий шалгалттай дүйцэх шалгалтын дүнгийн монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээний монгол хэл дээр баталгаат орчуулга
- Төгссөн сургуулийн QR код бүхий тодорхойлолт /монгол хэл дээр баталгаат орчуулгын хамт/
- 3*4 хэмжээтэй зураг 4 хувь
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт /Хаан банк, МУБИС-ийн захиргаа аж ахуй, Данс: 5031749242, Гүйлгээний утга: Паспорт дээрх нэр, паспортын дугаар/

Б. МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЭХ ГАДААД ИРГЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА


5.2.5 Бүртгүүлэгч нь Монгол улсын харьяат бус иргэн байх бөгөөд хууль эрх зүйн хувьд өөрийгөө бүрэн хариуцах чадамжтай байна.

5.2.6 Бүртгүүлэгч нь монгол хэл, бичгийн түвшин тогтоох шалгалтад 71, түүнээс дээш оноо авч тэнцэх ба 70-аас доош оноо авсан тохиолдолд монгол хэлний бэлтгэл ангид хэлний түвшнээс шалтгаалан 6-18 сар суралцана. МУБИС-ийн болон Монголын их, дээд сургуульд бакалаврын түвшинд суралцаж төгссөн бол шалгалтын комиссын шийдвэрээр шалгалтаас чөлөөлж болно.

5.2.7 Бүртгүүлэгч нь бакалаврын зэрэгтэй байна.

5.2.8 Бүртгүүлэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- Гадаад паспортын хуулбар /Паспортын нүүрэн хэсгийг дэлгэмэл байдлаар сканердсан хуулбар, хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байх/
- Эрүүл мэндийн хуудас
- Иргэний үнэмлэх /биеийн байцаалт/-ийн хуулбар
- Иргэний үнэмлэхийн монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
- Бакалаврын зэргийн дипломын хуулбар
- Бакалаврын зэргийн дипломын хуулбарын монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбар
- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбарын монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудас
- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудсыг монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
- Төгсөлтийг гэрчлэх QR код бүхий тодорхойлолт /монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулгын хамт/
- 3*4 хэмжээтэй зураг 4 хувь
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт /МУБИС-ийн бүрэлдэхүүний болон салбар сургуулийн дансанд шилжүүлнэ. Гүйлгээний утга: Паспорт дээрх нэр, паспортын дугаар/



В. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЭХ ГАДААД ИРГЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.2.9 Бүртгүүлэгч нь Монгол улсын харьят бус иргэн байх бөгөөд хууль эрх зүйн хувьд өөрийгөө бүрэн хариуцах чадамжтай байна.

5.2.10 Бүртгүүлэгч нь монгол хэл, бичгийн түвшин тогтоох шалгалтад 71, түүнээс дээш оноо авч тэнцэх ба 70-аас доош оноо авсан тохиолдолд монгол хэлний бэлтгэл ангид хэлний түвшнээс шалгаалан 6-18 сар суралцана.

5.2.11 Бүртгүүлэгч нь бакалаврын болон магистрын зэрэгтэй байна.

5.2.12 Бүртгүүлэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- Гадаад паспортын хуулбар /Паспортын нүүрэн хэсгийг дэлгэмэл байдлаар сканердсан хуулбар, хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байх/
- Эрүүл мэндийн хуудас
- Иргэний үнэмлэх /биеийн байцаалт/-ийн хуулбар
- Иргэний үнэмлэхийн монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын зэргийн дипломын хуулбар
- Бакалаврын зэргийн дипломын хуулбарын монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбар
- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбарын монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудас
- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудсыг монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
- Магистрын зэргийн дипломын хуулбар
- Магистрын зэргийн дипломын хуулбарын монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
- Магистрын дипломын цахим бүртгэлийн хуудас
- Магистрын дипломын цахим бүртгэлийн хуудасны орчуулга
- Сургууль төгссөн болохыг нотлох QR код бүхий тодорхойлолт монгол хэлээрх баталгаат орчуулгын хамт
- 3*4 хэмжээтэй зураг 4 хувь
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт /МУБИС-ийн бүрэлдэхүүний болон салбар сургуулийн дансанд шилжүүлнэ. Гүйлгээний утга: Паспорт дээрх нэр, паспортын дугаар/

ЗУРГАА. МУБИС-ИЙН ХАРЬЯА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТ

6.1. НЭГДҮГЭЭР АНГИЙН ЭЛСЭЛТ

6.1.1. Нэгдүгээр ангид элсэх суралцагч нь дараах нөхцелийг хангасан байна. Үүнд:

- Тухайн онд багтаж б нас хүрсэн байх

- Тус сургуулийн бэлтгэл бүлэгт хамрагдсан байх
- Суудал хадгалах гэрээ байгуулан тухайн жилийн сургалтын төлбөрийн 10%-ийг сургуулийн дансанд байршуулсан байх

6.1.2. 1-р ангийн элсэлт жил бүрийн 4 дүгээр сарын 1-ны өдрийн 10:00 цагаас цахимаар бүртгэнэ. Бэлтгэл бүлгийн хичээл 5 сард тодорхой төлбөртэй явагдах ба сургалтын хэрэглэгдэхүүн, үйийн цай, сургуультай танилцах арга хэмжээг сургуулийн захиргаанаас зохион байгуулна.

- 6.1.3. Суралцагчийг бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.
- Элсэгчийн төрсний гэрчилгээний хуулбар
 - Эцэг эх, асран хамгаалагчийн иргэний үнэмлэхний хуулбар
 - 3x4 хэмжээтэй 1 хувь цээж зураг

9087702 40 0021051159

ХОЁР БА ТҮҮНЭЭС ДЭЭШ АНГИЙН ЭЛСЭЛТ

6.2.1. 2-12 ангийн нэмэлт элсэлтийг зохион байгуулахдаа сурагчдын тоо, шилжилт хөдөлгөөнөөс хамаарч, тухайн хичээлийн жилийн эхэнд зарлаж явуулна.

6.2.2. Урьд нь суралцаж байсан сургуулийн бичиг баримт бүрэн, ямар нэгэн зөрчилгүй байх

6.2.3. Түвшин тогтоох шалгалтыг математик, монгол хэл, англи хэлний хичээлүүдээр авах бөгөөд анализыг суралцагч болон эцэг эхэд тусгайлан танилцуулна.

6.2.4. Тус сургуульд элсэн орсон сургачид тэдний эцэг, эх, асран хамгаалагчдад сургуулийн сургалтын онцлог, хичээлийн хуваарь, сургуулийн дүрэм, журмыг сургалтын менежер, ангийн багш нар танилцуулах үүрэг хүлээнэ.

6.2.5. Суралцагчийг бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- Суралцагчийн төрсний гэрчилгээний хуулбар
- Эцэг эх, асран хамгаалагчийн иргэний үнэмлэхний хуулбар
- 3x4 хэмжээтэй 1 хувь цээж зураг
- Суралцагчийн хувийн хэрэг, сурлагын дүнгийн хуудас

НАЙМ. ТӨЛБӨР ХУРААМЖ

8.1 Бакалавр, магистрантур, докторантурын элсэлтийн бүртгэлийн хураамж 30.000 төгрөг байна.

8.2 Бакалаврын элсэгчдийн бичиг баримт буцаалтын хураамж 100.000 төгрөг байна.

8.3 Гадаад элсэгчийн бакалавр, магистрантур, докторантурын элсэлтийн бүртгэлийн хураамж 120.000 төгрөг байна.


8.4 Гадаад оюутнаас авах Монгол хэл, бичгийн шалгалтын хураамж 50.000 төгрөг байна.

ЕС. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

9.1 Журмын хэрэгжилтийг элсэлтийн тушаал гарахад Тамгын газар болон Сургалт, цахим шилжилтийн хэлтсээс үнэлж, тайланг МУБИС-ийн Захиргааны зөвлөлд танилцуулна.

9.2 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд Элсэлтийн төв комисс санал гаргаж, МУБИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулна.

МУБИС-ИЙН 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТЕЛБОРТ ЭЛСЭЛТ АВАХ ХӨТЕЛБОР /МЭРГЭЖИЛ-ИЙН/ ЖАГСААЛТ



** Дээд боловсролын тэрэгүүлэх мэргэжил
* Дээд боловсролын эрэлттэй мэргэжил

№	Мэргэжлийн индекс	Хөтөлберийн нэр	Мэргэжлийн чиглэл	ЭШ-ын оноо тооцох хичээл	БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ				
					Судлах кредит	Суралцах жил	Хичээл-1	Хичээл-2	
1	011101	Боловсрол судлал	Боловсрол судлаач	Монгол хэл, Нийгэм судлал	Математик, Англи хэл	122	4 жил	480	450
2	031301	Сэтгэл судлал*	Сэтгэл судлаач	Нийтэм судлал, Математик	Монгол хэл, Англи хэл	124	4 жил	480	480
3	092301	Нийгмийн ажил*	Нийгмийн ажилтан	Нийтэм судлал, Англи хэл	Монгол хэл, Математик	124	4 жил	480	480
4	031301	Сэтгэл судлал*	Сэтгэл судлаач, сургуулийн сэтгэл зүйч	Нийтэм судлал, Математик	Монгол хэл, Англи хэл	124	4 жил	480	480
5	092301	Нийгмийн ажил*	Нийгмийн ажил, хүчинчийн арга зүйч	Нийтэм судлал, Англи хэл	Монгол хэл, Математик	124	4 жил	480	480
6	011426	Багш, насан туршийн боловсрол	Насан туршийн боловсролын багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	124	3.5 жил	450	480
7	011428	Багш, тусгай хэрэгцээт боловсрол*	Тусгай хэрэгцээт боловсролын багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	124	3:5 жил	450	480
МАТЕМАТИК, БАЙГАЛИЙН УХДАНЫ СУРГУУЛЬ									
8	011401	Багш, математикийн боловсрол*	Математикийн багш	Математик	Физик, Англи хэл	125	4 жил	480	480

9	011403	Багш, мэдээлэл зүйн боловсрол*	Мэдээлэл зүйн баш	Математик	Ур чадварын шалгалт	125	4 жил	480	480
10	011409	Багш, физикийн боловсрол*	Физикийн баш	Физик, Математик	Математик, Англи хэл	125	4 жил	480	480
11	011405	Багш, химийн боловсрол*	Химийн баш	Хими, Математик	Биологи, Англи хэл, Физик	125	4 жил	480	480
12	011411	Багш, газарзүйн боловсрол*	Газарзүйн баш	Газарзүй, Математик	Англи хэл, Нийгэм судлал	125	4 жил	480	480
13	011439	Багш, эрүүл мэндийн боловсрол, ага зүй	Эрүүл мэндийн баш, ага зүйч	Нийгэм судлал, Биологи	Монгол хэл, Түүх	127	4 жил	450	450
14	061302	Программ хангамж*	Программ хангамжийн инженер	Математик, Физик	Нийгэм судлал, Англи хэл	123	4 жил	480	450
15	011407	Багш, биологийн боловсрол*	Биологийн баш	Биологи, Математик	Хими, Англи хэл	125	4 жил	480	480
16	052101	Экологи	Экологич	Биологи, Математик	Хими, Нийгэм судлал	123	4 жил	480	450
НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГИЙН УХДАНЫ СУРГУУЛЬ									
17	011413	Багш, нийгмийн ухааны боловсрол	Нийгмийн ухааны баш	Нийгэм судлал	Түүх, Монгол хэл	124	4 жил	480	480
18	011413	Багш, нийгмийн ухааны боловсрол	Түүхийн баш	Нийгэм судлал	Түүх, Монгол хэл	124	4 жил	480	480
19	011413	Багш, нийгмийн ухааны боловсрол	Түүх, нийгмийн ухааны баш	Нийгэм судлал	Түүх, Монгол хэл	124	4 жил	480	480
20	032202	Архив судлал	Архив, албан хэрэг хөтөлбөр	Монгол улсын түүх, Монгол хэл	Нийгэм судлал, Математик	123	4 жил	480	450
21	101502	Түүх, соёлын аялал жуулчлал	Түүх, соёлын аялал жуулчлал	Монгол улсын түүх, Англи хэл	Ур чадварын шалгалт	122	4 жил	480	480
22	011430	Багш, монгол хэл уран зохиолын боловсрол	Монгол хэл, уран зохиолын багш	Монгол хэл	Нийгэм судлал, Монгол улсын түүх	124	4 жил	480	480
23	023201	Хэл, уран зохиол	Хэл, уран зохиол судлаач	Монгол хэл	Нийгэм судлал, Монгол улсын түүх	125	4 жил	480	480



24	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Англи хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
25	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Орос хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
26	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Хягад хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
27	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Солонгос хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
28	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Герман хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
29	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Япон хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
30	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Герман, англи хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
31	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Орос, англи хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
32	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Япон, англи хэлний багш	Англи хэл, Орос	Монгол хэл, Нийгэм Судлал	124	4 жил	480	480
33	032101	Сэтгүүл зүй	Сэтгүүлч	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	125	4 жил	480	480
БАГШИЙН СУРГУУЛЬ									
34	011301	Багш, бага боловсрол*	Бага английн багш	Монгол хэл, Математик	Ур чадварын шалгалт	126	3.5-4 жил	450	480
35	011424	Багш, хөгжмийн боловсрол*	Хөгжмийн багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	124	4 жил	450	480
БИЕИЙН ТАМИРИЙН СУРГУУЛЬ									
36	011437	Багш, биеийн тамирын боловсрол	Биеийн тамирын багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	125	4 жил	450	480
37	101402	Биеийн тамирын арга зүй	Биеийн тамирын арга зүйч	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	125	4 жил	480	480
38	101402	Биеийн тамирын арга зүй	Биеийн тамирын багш, арга зүйч	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	160	4.5-5 жил	450	480

39	101401	Спортын дасгалжуулагч	Спортын дасгалжуулагч, биеийн тамирын Багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгатт	160	4.5-5 жил	480	480
40	101401	Спортын дасгалжуулагч	Спортын дасгалжуулагч	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгатт	160	4.5-5 жил	480	480
41	101503	Спорт аялал жуулчлал	Спорт аялал жуулчлал	Нийгэм судлал, Англи хэл	Ур чадварын шалгатт	124	3.5-4 жил	480	480
42	032101	Сэтгүүл зүй	Спортын сэтгүүлч	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгатт	124	3.5-4 жил	480	480
ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ									
43	011419	Багш, дурслэх урлагийн боловсрол	Дурслэх урлагийн багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгатт	127	3.5-4 жил	450	480
44	011422	Багш, дизайн зураг зүйн боловсрол	Дизайн зураг зүйн багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгатт	127	3.5-4 жил	450	480
45	011420	Багш, дизайн технологийн боловсрол	Дизайн технологийн багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгатт	127	3.5-4 жил	450	480
46	021105	График дизайн*	Компьютер график дизайн	Математик, Англи хэл	Ур чадварын шалгатт	127	4 жил	450	480
47	021105	График дизайн*	Компьютер график дизайн	Математик, Англи хэл	Ур чадварын шалгатт	127	4 жил	450	480
48	021202	Хувцас дизайн	Хувцас дизайн	Математик, Англи хэл	Ур чадварын шалгатт	128	4 жил	450	480
СУРГУУЛИЙН ӨМНХ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ									
49	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол*	Сургуулийн өмнөх боловсролын Багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгатт	124	3,5- 4 жил	440	480
50	011301	Багш, бага боловсрол*	Бага ангийн багш	Монгол хэл, Математик	Ур чадварын шалгатт	126	3.5-4 жил	420	420

908480 9020515480
480 480
480 480

51	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол*	Сургуулийн өмнөх боловсролын багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	124	3,5- 4 жил	420	420	420	420
52	011430	Багш, монгол хэл уран зохиолын боловсрол	Монгол хэл, уран зохиолын багш	Монгол хэл	Нийгэм судлал, Монгол улсын түүх	124	4 жил	420	420	420	420
53	011401	Багш, математикийн боловсрол*	Математикийн багш	Математик	Физик, Англи хэл	125	4 жил	420	420	420	420
54	011413	Багш, нийтийн ухааны боловсрол	Түүх, нийтийн ухааны багш	Нийгэм судлал	Түүх, Монгол хэл	124	4 жил	420	420	420	420
55	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Англи хэлний багш	Англи хэл, Орос хэл	Монгол хэл, Нийгэм судлал	124	4 жил	420	420	420	420
56	092301	Нийгмийн ажил*	Нийгмийн ажилтан	Нийгэм судлал, Англи хэл	Монгол хэл, Математик	124	4 жил	420	420	420	420
57	011403	Багш, мэдээлэл зүйн боловсрол*	Мэдээлэл зүйн багш	Математик	Ур чадварын шалгалт	125	4 жил	420	420	420	420
58	031301	Сэтгэл судлал*	Сэтгэл судлаач	Нийгэм судлал, Математик	Монгол хэл, Англи хэл	124	4 жил	420	420	420	420
БАЯН-ӨЛГИЙ											
АЙМАГ ДАХЬ											
САЛБАР											
СУРГУУЛЬ											
59	011301	Багш, бага боловсрол*	Бага ангийн багш	Монгол хэл, Математик	Ур чадварын шалгалт	126	3.5-4 жил	420	420	420	420
60	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол*	Сургуулийн өмнөх боловсролын багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	124	3,5- 4 жил	420	420	420	420
61	011424	Багш, хөгжмийн боловсрол*	Хөгжмийн багш	Монгол хэл, Нийгэм судлал	Ур чадварын шалгалт	124	4 жил	420	420	420	420
62	011401	Багш, математикийн боловсрол*	Математикийн багш	Математик	Физик, Англи хэл	125	4 жил	420	420	420	420
63	071201	Хүрээлэн буй орчны инженерчлэл**	Хүрээлэн буй орчны инженерчлэл**	Хими, Математик	Физик, Англи хэл	125	4 жил	420	420	420	420